

# ЭТИОПТ НЭР ТӨРӨӨ ӨНДӨРТ ӨРГӨН АВЧ ЯВАХ НЬ

Эми Жэйн Лэвитт  
Зохиогч нь АНУ-ын  
Ютад амьдардаг.

## Намайг ЦИОН гэдэг.

Би Зүүн Африкт орших Этиоп гэдэг улсад амьдардаг. Би хөл бөмбөг тоглож, ном унших дуртай. Бас би том болохоороо эмч болохыг хүсдэг. Би өдөр бүр сайн мэдээний дагуу амьдарч, үүнийг найз нөхөдтэйгөө хуваалцсанаар нэр төрөө өндөрт өргөж явахыг хүсдэг.

### БИ ЯАЖ ГЭРЧЛЭЛТЭЙ БОЛСОН БЭ?

Би найман настай байхдаа анх удаа сүмд очсон юм. Би Мормоны Номыг уншин, номлогчдыг сонсож, залбирсан. Сүнс надад Сүм үнэн гэдгийг хэлж, би баптисм хүртэхийг хүссэн билээ. Сайн мэдээ намайг аз жаргалтай болгодог.



ЗУРГИЙГ ЦИОНЫ ГЭР БҮЛЭЭС ИРҮҮЛСЭН БОЛНО. ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАРК РОБИНСОН.

### ГЭР БҮЛИЙНХЭНДЭЭ ТУСЛАХ НЬ

Манай гэр бүлийнхэн сүм рүү ихэвчлэн цаг гаруй алхаж очдог. Бага дүү маань ядарвал ах маань эсвэл би түүнийг үүрч явдаг. Би аяга тавгаа угааж, гэр орноо цэвэрлэн, гэр орныхоо ажилд тусалдаг.



### МЭДДЭГ ЗҮЙЛСЭЭ ХУВААЛЦАХ НЬ

Би сургуулийнхаа найзуудад сэргээгдсэн сайн мэдээний талаар ярьж өгдөг. Нэг найз маань Сүмийн талаар надаас асуудаг байснаа гэнэт асуухаа больсон юм. Би тэр охиноос яагаад гэдгийг асуув. Эцэг эх нь дургүй байсан гэж тэр хэлсэн. Хэзээ нэгэн цагт түүний эцэг эх бодол санаагаа өөрчлөх байх гэж би найдаж явдаг.

### ӨӨРИЙН ТҮҮХИЙГ БИДЭНД ИЛГЭЭ

Та нар нэр төрөө өндөрт өргөн авч явснаар хэрхэн Есүсийг дагадаг вэ? Хариулт болон зургаа, эцэг эхийнхээ зөвшөөрөлтэй хамт бидэнд илгээгээрэй. Та бидэн рүү [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) гэсэн э-мэйл хаягаар илгээнэ үү.

### НЭР ТӨРӨӨ ХЭРХЭН ӨНДӨРТ ӨРГӨН АВЧ ЯВАХ ТАЛААР ӨГӨХ ЦИОНЫ ЗӨВЛӨГӨӨ

- Өөрийн гэсэн гэрчлэлтэй бол. Судруудыг уншиж, залбир.
- Гэрчлэлээ хуваалцаж, найзууддаа сайн үлгэр жишээ үзүүл.
- Ням гараг бүр сүмдээ явж, сайн мэдээний жишгийн дагуу амьдар.

### МИНИЙ СҮМИЙН ДУУДЛАГА

Миний хамгийн дуртай Сүмийн үйл ажиллагаа бол ариун ёслолын цуглаан юм. Би цуглаан дээр дуу удирддаг.

Би сайн мэдээний талаар суралцах дуртай. Миний хамгийн дуртай судрын түүх бол Давид, Голиаф хоёрын тухай түүх юм. Харин миний дуртай дуу бол "Мормоны Номын түүх."



### НЭР ТӨРӨӨ ӨНДӨРТ ӨРГӨН АВЧ ЯВАХ ГЭДЭГ НЬ МИНИЙ ХУВЬД ЯМАР УТГА УЧИРТАЙ ВЭ?

"Нэр төрөө өндөрт өргөн авч явах" гэдэг нь өдөр бүр сайн мэдээний дагуу амьдрахыг хэлнэ. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр намайг Тэдний тухай гэрчилж байгаасай хэмээн хүсдэг. Дэлхийн олон улс оронд байх миний бүх найз нөхөд сэргээгдсэн сайн мэдээг найз нөхөдтэйгөө хуваалцаасай гэж би хүсдэг.

